



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/12

Амардалай

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дахь заалт, Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх "Сургуулийн сагсны талбайн тохижилт"-ын ажлын тендер сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Баттогтох (ЗДТГ-ын мэргэжилтэн)

Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга: Н.Сүрьеэрагчаа (Цэцэрлэгийн багш)

Гишүүд: Г.Дэжидсүрэн (ЗДТГ-ын мэргэжилтэн)

Д.Баяржаргал (Хөндлөнгийн гишүүн)

Б.Довуучий (Залуучуудын холбоо)

2. Тендер шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журмын дагуу хариуцлагатай, шударга зохион байгуулахыг Үнэлгээний хорооны гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг архивын нэгж бүрдүүлж, хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Н.Сүрьеэрагчаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

422601019